

ТАНИЛЦУУЛГА

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай”
Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж, Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал (УИХ) цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурал 2024 оны 12 сарын 27-ны өдөр баталсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд байгуулсан аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээнүүд нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал бөгөөд дээрх хуульд заасны дагуу Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь буюу гишүүн энэхүү асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах санал гаргаад байна.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд байгуулсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг судлан шалгаж, хэрэв Монгол Улсад ашиггүй байх нөхцөлөөр тогтоосон бол түүнийг яаралтай шинэчлэн шийдвэрлэхэд Улсын Их Хурлын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатай байна.

Нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонноос бууруулахгүй, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн уурхайн олборлолтын төлөвлөгөөтэй нийцүүлэн коксжих, сул коксжих, эрчим хүчний нүүрсийг зохимжит хувь харьцаагаар нийлүүлэх буюу зөвхөн нэг төрлийн нүүрсийг сорчлохгүй байх талаарх асуудлыг хянан шалгаж тогтоосноор манай улсын экспортын орлогыг оновчтой төлөвлөх боломжийг зөв тодорхойлох нь нэн чухал байна.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бичиг баримт, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэх судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг тэнцвэрт мэдээллээр хангах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурал 2024 оны 12 сарын 27-ны өдөр баталсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах

тухай” 58 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр асуудлаар дагнасан хяналт, шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж, иргэдийг мэдээллээр хангах, тайланг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолын төслийг боловсрууллаа.

---o0o---